

## **ХЯТАД, МОНГОЛЫН САЙН ХӨРШИЙН ХАРИЛЦАН ИТГЭСЭН ТҮНШЛЭЛИЙН ХАРИЛЦААНЫ ШИНЭ ТӨЛӨВ**

*Наран\**

Хятад, Монгол хоёр болбоос ул усаар холбогдсон найрсаг хөршүүд бөгөөд хоёр орны хилийн шугамын урт 4677 км бөгөөд энэ нь Хятадын хуурай газраар хиллэдэг 15 улсын дотор хамгийн урт нь болно. Хятад, Монгол хоёр орон 1949 оны 10-р сарын 16-нд дипломат харилцаа тогтоосноос хойшхи 55 гаруй жилд хэдийгээр ээдрээтэй зам туулсан ч сайн хөршийн найрсаг харилцаа гол хандлага нь байлаа. 1989 оноос хойш хоёр орны харилцаа хэвийн болсноос хойш, ялангуяа сүүлийн 10 гаруй жилд хоёр талын хамтын хүчин чармайлтаар хоёр орны харилцаа хөгжлийн шинэ түвшинд хүрээд байна. Улс төрийн хүрээнд бие биеийнхээ тусгаар тогтнол, бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдал болон улс орныхоо нөхцөл байдлыг харгалзан хөгжлийн замаа сонгож авсан байдлыг харилцан хүндэтгэн, сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцааг хамтдаа байгуулаад байна; эдийн засгийн хүрээнд харилцан ашигтай хамтын ажиллагааг ихээхэн идэвхитэй хөгжүүлэн хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцаа шинэ өндөрлөгт хүрээд байна.

Эдүгээ Хятад, Монголын харилцаа түүхийн хамгийн сайн үедээ байж, хоёр орны харилцаа улс төр, эдийн засаг худалдааны хамтын ажиллагаа хийгээд бүхий л салбарын харилцаа хөгжлийн шинэ шатанд орлоо. Хятад, Монголын харилцааг хөгжүүлэх нэн сайхан нөхцөл тохиож байна.

### **Нэг. Хятад, Монголын харилцааны түүхийн нэн сайн үе**

1. Дээд хэмжээний харилцан айлчлалын тоо нэмэгдэж, улс төрийн харилцан итгэлцэл гүнзгийрэв.

1990-ээд оны эхэн үеэс хойш Хятад улсын дарга Янь Шанкунь, Зянь Зэминь, Ху Жиньтао нар болон Ерөнхий сайд Ли Пэн хийгээд БХАТИХ-ын Байнгын хорооны дарга Цяо Ши нар удаа дараалан Монгол Улсад айлчлав. Монголын хоёр Ерөнхийлөгч, УИХ-ын хоёр дарга, дөрвөн ерөнхий сайд Хятадад айлчиллаа. Эдгээр дээд хэмжээний айлчлалууд нь хоёр орны харилцааны тасралтгүй хөгжилд идэвхитэй түлхэц үзүүлж хоёр орны улс төрийн харилцааг улам ахиулав.

---

\*Наран - Өвөр Монголын Их сургуулийн Хөрш орон судлалын хүрээлэн. Доктор, профессор

1990 оны 5-р сард Монгол Улсын АИХ-ын дарга П.Очирбат /тэрбээр мөн оны 9-р сард Монголын анхны Ерөнхийлөгчөөр сонгогдов. Зох./ БНХАУ-д айлчлав. Монголын төрийн тэргүүн анх удаа гадаадад айлчлахдаа Хятадыг сонгосон нь урьд өмнө Монголын шинэ удирдагчид эн түрүүнд заавал ЗХУ-д айлчилдаг арга барилтай огт адилгүй хэрэг байв. 1991 оны 8-р сард БНХАУ-ын дарга Янь Шанкунь Монголд айлчилсан нь хоёр орон 1949 онд дипломат харилцаа тогтоосноос хойш Хятадын төрийн тэргүүний Монголд хийсэн анхны айлчлал болсон бөгөөд энэ нь Хятад, Монголын харилцааны шинэ үеийг нээсний билэг тэмдэг болов. 1994 оны 4-р сард БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Пэн Монголд айлчилж, хоёр орны харилцааг эрүүлжүүлэх, тогтвортой хөгжүүлэх бодит улс төр, хууль эрхийн үндэс суурийг бий болгохын тулд хоёр тал “БНХАУ, Монгол Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээ”-нд гарын үсэг зурав.

1998 оны 12-р сард Зянь Зэминь даргын урилгаар Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди БНХАУ-д төрийн айлчлал хийж, хоёр тал “Хятад, Монголын хамтарсан мэдэгдэл” гаргаж, хоёр орны ХХI зуунд хандсан урт хугацааны тогтвортой, эрүүл саруул, харилцан итгэлцсэн, сайн хөршийн найрсаг харилцаа тогтоон бий болгож, хоёр орны харилцааны ирээдүйн хөгжлийн хандлагыг чиглүүлэн зааж өгөв. 1999 оны 7-р сард БНХАУ-ын дарга Зянь Зэминь Монгол Улсад төрийн айлчлал хийж, хоёр орны сайн хөршийн найрсаг харилцаа хамтын ажиллагааны агуулгыг нэмэн баяжуулж, хоёр орны найрсаг харилцан итгэлцлийг улам бэхжүүллээ. 2002 оны 1-р сард Монголын Ерөнхий сайд Н.Энхбаяр Хятадад албан ёсны айлчлал хийж, хоёр тал “Хятад, Монголын хамтарсан албан мэдээ” нийтлүүлэв.

2003 оны 6-р сарын 4-5-нд БНХАУ-ын дарга Ху Жиньтао Монгол Улсад төрийн айлчлал хийсэн нь Хятадын шинэ үеийн удирдагчид хөршдөө найрсаг хандах, түншлэх чиг хандлага барьж Монголтой найрсаг, хамтран ажиллах улам идэвхитэй байр суурь баримталж байгааг харуулав. Ху Жиньтао дарга Монголд айлчлах хугацаанд хоёр тал Хятад, Монголын сайн хөршийн харилцан итгэлцсэн түншийн харилцаа тогтоон хөгжүүлэхээ тунхаглаж, хоёр орны харилцааг хөгжлийн шинэ түвшинд гаргалаа. Мөн “Хятад, Монголын хамтарсан албан мэдээ” нийтэлж, хоёр тал харилцан ашигтай, харилцан хөнгөлөлттэй эдийн засаг худалдааны харилцаагаа улам өргөжүүлж, байгалийн баялгийг ашиглах, дэд бүтцийг хөгжүүлэх явдлыг хоёр улсын цаашдын хамтын ажиллагааны чухал салбар болгохоор тохиролцов.

Энэхүү айлчлал амжилттай болсоноор хоёр орны хоорондын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд шинэ түлхэц өглөө. Энэ айлчлалаас яг нэг жилийн дараа 2004 оны 7-р сарын 1-6-ны хооронд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Хятадад хариу айлчлал хийв. Хоёр тал “Хятад-Монголын хамтарсан мэдэгдэл” гаргаж Хятад, Монголын хооронд сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцаа тогтож, хоёр орны найрсаг харилцаа, хамтын ажиллагаа шинэ агуулга, хэлбэрээр баяжин амжилттай хөгжиж байгаад сэтгэл ханамжтай буйгаа илэрхийлэв. Талууд хамтын хөгжлийн төлөө байгалийн баялгийг нээн ашиглах, дэд бүтцийн хөгжлийг гол чиглэл болгосон харилцан ашигтай хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэн гүнзгийрүүлэхээр тохиролцов.

Улс төрийн харилцаа хөгжин гүнзгийрэхийн зэрэгцээ хоёр орны цэргийн харилцаа амжилттай хөгжиж байна. 1991-1992 онуудад хоёр орны БХЯ-ны сайд нар харилцан айлчилснаар хоёр орны цэргийн харилцаа сэргэн хэвийн болсон юм. 1997 оны 11-р сард Монголын БХЯ-ны сайд Дорлигжав Хятадад айлчилж, “Хятад, Монголын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хэлэлцээр”-т гарын үсэг зурав. 2000 оны 1-р сард, Хятадын БХЯ-ны сайд Чи Хаотянь Монголд, 2001 оны 6-р сард Монгол Улсын БХЯ-ны сайд Ж.Гүррагчаа Хятадад айлчилж, хоёр тал харилцан ойлголцол, итгэлцлээ ахиулав. 2003 оны 10-р сард Хятадын БХЯ-ны сайд Цао Ганчуань айлчлалаар ирсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга Ц.Тогоог хүлээн авч уулзахдаа “Хятадын тал Монголын хамт хоёр орны цэргийн салбарт найрсаг харилцаагаа үргэлжлүүлэн хөгжүүлэхийн төлөө байна” хэмээн мэдэгдсэн. 2004 оны 10-р сард Хятадын Ардын чөлөөлөх Армийн Жанжин штабын орлогч дарга Сюн Гуанкай Монгол Улсад зочилж Хятад, Монгол анх удаа батлан хамгаалах, аюулгүй байдлын асуудлаар зөвлөлдөөн хийв. Энэ үеэр Сюн Гуанкай хэлэхдээ “Хятад улс “харилцан итгэх, харилцан ашигтай, эрх тэгш, уялдан зохицох” зарчимд тулгуурласан аюулгүй байдлын шинэ үзэл ойлголтыг хөгжүүлэх хүсэл эрмэлзлийн дагуу улс орнуудтай солилцоо, хамтын ажиллагаагаа хөгжүүлж байна” гэв. Хятад, Монгол анх удаа батлан хамгаалах, аюулгүй байдлын асуудлаар зөвлөлдөөн хийсэн нь Хятад, Монголын сайн хөршийн харилцан итгэлцсэн түншийн харилцааг хөгжүүлэх чухал агуулга болсон юм.

Эдгээр дээд хэмжээний уулзалтууд нь Хятад, Монголын төр засгийн болон цэргийн харилцааг цуцалтгүй урагшлуулах, харилцан

ойлголцол, итгэлцлийг нэмэгдүүлж, Хятад, Монголын сайн хөршийн харилцан итгэлцсэн түншийн харилцааг хөгжүүлэх үйлсэд түлхэц өгсөн чухал ач холбогдлыг агуулж байлаа.

2. Хятад, Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа тасралтгүй өргөжин тэлж байна.

*Хятад бол Монгол Улсын худалдааны хамгийн том түнш мөн.* 2003 онд Монгол Улсын гадаад худалдааны нийт хэмжээ 1416.9 сая ам.долларт хүрч, Монгол, Хятадын худалдааны хэмжээ 483 сая ам.доллар болж Монголын гадаад худалдааны 34%-ийг эзэлж байна. Түүний дотор Монголоос Хятад руу гаргасан экспорт 287 сая ам.доллар, импорт 196 сая ам.долларт хүрч Монголын гадаад худалдааны экспортын 46.6 %, импортын 24.5%-ийг эзэлж байна. Хятад улс бол Монголын хамгийн том экспортлогч орон, импортын хувьд ОХУ-ын дараа 2-р байр эзэлдэг.

Монголоос Хятадад гаргадаг экспортын зонхилох бараа бол зэсийн баяжмал, мал аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий нефть, хаягдал төмөр, зэс зэрэг юм. 2003 онд Хятадад 557.5 мянган тн зэсийн баяжмал /160 сая ам.долл/, молибден 39 мянган тн /15 сая ам.долл/, 139.9 мянган баррель нефть /3.98 сая ам.долл/ ямааны самнасан ноолуур 277 тн /12.7 сая ам.долл/ мал аж ахуйн түүхий эдийн экспортын хэмжээ 20 сая ам.долларт хүрэв. Монгол Улс Хятадаас гол төлөв хөнгөн аж үйлдвэрийн бараа, цагаан будаа, жимс, хүнсний ногоо, дундаас доош түвшний өдөр тутмын хэрэглээний барааг импортоор авдаг.

*Хятад улс Монголын хамгийн том хөрөнгө оруулагч.* Хөрөнгө оруулалтын хувьд гэвэл, 1990 оноос 2003 оны эцэс хүртэл 73 орны 3042 үйлдвэр аж ахуйн нэгж Монголд 1 тэрбум ам.долларын хөрөнгө оруулжээ. Хятадаас 1059 үйлдвэр, аж ахуйн нэгж Монголд 379 сая ам.долларын хөрөнгө оруулсан нь Монголын гадаад хөрөнгө оруулалттай нийт үйлдвэр, аж ахуйн газрын 34.8%, хөрөнгө оруулалтын 37.9%-ийг эзэлж байна.

1998 оноос Монгол дахь Хятадын хөрөнгө оруулалт 6 жил дараалан тэргүүлэх байр суурь эзэлж байна. Хятад, Монголын хамтарсан хамгийн том хамтын ажиллагааны төсөл бол Төмөртэйн овооны цайрын уурхай бөгөөд Хятадын тал 200 сая юаний зээллэгэ олгож, Хятадын өнгөт төмөрлөгийн бүтээн байгуулалтын хувьцаат компани уурхайн ажлыг хариуцан хийж байна. Эдүгээ бэлтгэл ажил хийгдэж байгаа ба 2005 оны эхний хагас жилд ашиглалтад орох юм. Тус уурхай 1 жилд 70 000 тн цайрын баяжмал гаргах хүчин чадалтай,

ашиглалтын хугацаа 27 жил, нэг жилийн ашиг 18-20 сая ам.доллар болно. Хятад улс Монголын “Мянганы зам”-ын их бүтээн байгуулалтанд чухал үүрэг гүйцэтгэж байгаа ба түүнд Хятадын зам барилгын 4 компани, 2000 гаруй инженер техникийн ажилтан, ажилчид оролцож байна. Энэ зам Монгол орныг зүүнээс баруун, урдаас хойш нэвт дайрах ба ОХУ, БНХАУ-тай шууд холбогдох тул ирээдүйд Ази-Европыг холбосон гол магистрал зам болох юм. Үүнээс гадна Хятад улс Монголын баруун бүс нутгийг цахилгаан эрчим хүчээр хангах талаар үр ашигтай хамтран ажиллаж байна. 2004 оны 6-р сард Хятадын групп Дөргөний усан цахилгаан станцыг/УЛС/ барьж эхэлсэн ба Хятадын тал 2 жилийн дотор уг УЛС-ыг барих бөгөөд ингэснээр ОХУ-аас эрчим хүч импортлодог, эрчим хүчний үнийг төлөөгүйн улмаас гэрэл цахилгаан байнга тасардаг явдал эцэс болох юм.

*Хятад улсаас Монголд үзүүлэх зээл тусламж улам бүр нэмэгдэх хандлагатай байна.* Хятад, Монгол хоёр орон дипломат харилцаа тогтоосон 1949 оноос 2002 оны эцэс хүртэл Хятадаас Монголд нийтдээ 1 тэрбум гаруй юаний хөнгөлөлттэй зээл, тусламж үзүүлсэн байна. Харин 1991-2002 оны эцэс хүртэлх хугацаанд үзүүлсэн зээл тусламжийн хэмжээ 591 сая юанд хүрсний дотор 130 сая юаний хүүгүй зээл, 200 сая юаний хөнгөлөлттэй зээл, бусад нь буцалтгүй тусламж ажээ. 2002 оны 6-р сард Хятадын Гадаад эдийн засаг, худалдааны яамны сайд Ши Гуаншэн Монголд айлчилж, Хятадаас 1950-1960-аад онд олгосон зээлийн хугацааг сунгаж, 2007 оноос хойш төлөхөөр тохиролцов. 2003 оны 6-р сард БНХАУ-ын дарга Ху Жиньтао Монгол Улсад айлчлах үед Хятадын тал Монголд 50 сая юаний буцалтгүй тусламж болон уул уурхайн баялгийг нээж ашиглах, дэд бүтцийг хөгжүүлэхэд зориулан 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл олгохоор болов. 2003 оны 11-р сард Монгол Улсын Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан Хятадад айлчлах үед Хятадын тал Монголд дахин 30 сая юаний буцалтгүй тусламж олгов. Ингэснээр зөвхөн 2003 онд Хятадаас Монголд олгосон буюу олгохоор амласан зээл тусламжийн хэмжээ 2.56 тэрбум юанд хүрсэн нь өмнөх 50 жилийн үзүүлэлтийг давж байна. Энэ оны 7-р сарын эхээр Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Хятадад айлчлах үеэр Хятадын тал дахин 50 сая юаний буцалтгүй тусламж үзүүлэхээр болсон билээ. Хоёр улс дипломат харилцаа тогтоосноос хойш өнөөг хүртэлх хугацаанд Хятад улс Монголд нийтдээ 3.6 тэрбум юаний зээл, тусламжийг үзүүлээд байна.

*Хилийн худалдаа Хятад, Монголын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд чухал байр суурь эзэлж байна.* 1985 оноос хойш Өвөр Монгол, Синьзян-Уйгур, Нинся-Хотон зэрэг Өөртөө Засах Орон, Хэбэй, Ганьсу, Зилинь зэрэг мужууд Монголын холбогдох аймаг, бүс нутаг, салбаруудтай хилийн худалдаа хийж байна. Өвөр Монгол ба Монгол Улсын хооронд хийж буй хил худалдаа, техник-эдийн засгийн хамтын ажиллагаа нь Хятад, Монголын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаанд томоохон байр суурь эзэлдэг. 1983-2003 онд ӨМӨЗО, Монгол Улсын хоорондын худалдааны хэмжээ 1710 сая ам.долларт хүрч, мөн үеийн хоёр орны худалдааны нийт хэмжээний (3190 сая ам.доллар) 54% эзэлсэн байна. 2003 онд Өвөр Монгол, Монгол Улстай хийсэн худалдаа 220 сая ам.доллар байсан нь тухайн онд Монгол, Хятадын худалдааны нийт хэмжээний 46% болж байна. 2003 оны эцсийн байдлаар барьж байгуулах, ажиллах хүч нийлүүлэх, зураг төсөл, зөвлөлгөө өгөх гэх мэт чиглэлийн нийт 355 төсөл хэрэгжүүлэхээр гарын үсэг зурсан ба тэдгээрийн гэрээний нийт өртөг 150 сая ам.долларт хүрчээ. Монголд очсон ажиллах хүчин 7167 хүн/удаа болж, 200 сая гаруй ам.долларын тоног төхөөрөмж түүхий эд оруулжээ. Хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа өргөн хэрэглээний бараа, түүхий эд гэх мэт дагнасан өрөөсгөл байдлаас гарч уул уурхай нээх, тоног төхөөрөмж нийлүүлэх, газар тариалан эрхлэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах, барилга байгууламж барих гэх мэт олон чиглэлээр өргөжин тэлж байна.

### 3. Хоёр орны соёл, боловсролын хамтын ажиллагааны ололт амжилт.

Монгол, Хятадын харилцаа хэвийн болсоноос хойш хоёр орны Засгийн газар соёл, боловсролын салбарт урт хугацаанд ба жилийн хамтран ажиллах хэлэлцээрт гарын үсэг зурав. Соёлын солилцооны хувьд хоёр орны Засгийн газрын төлөвлөгөөний дагуу, хоёр тал олон сувгаар, бүх түвшинд, олон хэлбэрийн соёлын солилцоо, хамтын ажиллагаа явуулж, хоёр орны ард түмний харилцан ойлголцлыг нэмэгдүүлэв. 2004 оны 4-р сард Хятад улсын Соёлын яам, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам хамтран Монголд “Хятадын соёлын өдрүүд”-ийг зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээнд Хятадын үндэсний хөгжим, фото зургийн үзэсгэлэн, кино өдрүүд, цирк, дуу бүжгийн тоглолт багтсан байлаа. Амжилттай болж өнгөрсөн “Хятадын соёлын өдрүүд” нь хоёр ард түмний ойлголцол, найрамдлыг гүнзгийрүүлж, хөрш хоёр орны сайн хөршийн харилцан

итгэлцсэн түншийн харилцааг улам баяжуулсан билээ. Энэ үеэр Хятад улсын Соёлын сайд Сунь Зяжэн Монголд зочлох үеэр хоёр тал ойрын хугацаанд соёлын хамтын ажиллагааг хөгжүүлэх талаархи зорилтыг тодруулах зорилгоор “Хятадын засгийн газар ба Монголын засгийн газрын хооронд 2004-2006 онуудад соёлын солилцоо хийх төлөвлөгөө”-нд гарын үсэг зурсан юм. Энэхүү төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2005 онд Хятад улсад “Монголын соёлын өдрүүд”-ийг зохион явуулахаар тохиролцжээ.

Боловсролын салбарт, 1998 онд “БНХАУ-ын Засгийн газар ба Монгол Улсын Засгийн газар эрдмийн зэрэг, боловсролын үнэмлэхийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр”, 2000 онд “Хятадын буцалтгүй тусламжаар Монголын оюутныг сургах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд тус тус гарын үсэг зурав. Оюутан, мэргэжил дээшлүүлэгч, эрдэмтэн солилцоо жилээс жилд өслөө. Монголоос Хятадад улсын болон хувийн зардлаар суралцаж буй мэргэжил дээшлүүлэгч, оюутан, аспирантын тоо бараг 3000-д хүрч, Хятадаас Монголд мэргэжил дээшлүүлэгч, оюутны тоо 100 гаруй болоод байна. Хоёр талын хүн солилцоо нэмэгдэхийн хэрээр Монголд хятад хэл сурах хандлага сонирхол өслөө. Одоо Улаанбаатарт улсын болон хувийн их, дээд, дунд сургуулиудад 2000 оюутан сурагч хятад хэл үзэж байгаагаас гадна Монголын Дорнод, Ховд, Дархан, Замын-Үүд зэрэг аймаг хотуудын зарим дунд сургуулиуд хятад хэлийг зааж эхлээд байна.

Хятад, Монгол хоёр орон улс төр, худалдаа, эдийн засаг, соёл боловсрол зэрэг олон салбарт харилцааг бүх талаар хөгжүүлэн бэхжүүлэх таатай чиг хандлага гарч ирсэн нь сайн хөршийн харилцан итгэлцсэн түншийн харилцаа тогтоон хөгжүүлэх урьд өмнө байгаагүй таатай нөхцөл боломжийг бүрдүүлсэн билээ. Харин Хятад, Монголын харилцаанд зарим нэг эмзэг асуудлууд байсаар байна. Жишээлбэл, Монгол-Тайваний харилцаа, Монгол-Далай ламын харилцаа, Монгол ба АНУ зэрэг Өрнөдийн орнуудын “хөршийн харилцаа” гэх мэт зайлсхийх боломжгүй асуудлууд байна. Эдгээр нь хоёр орны харилцааны гол чиглэл биш боловч Хятад, Монголын харилцаанд сөргөөр нөлөөлөх талтай. Энэ байдал нь хоёр орон сайн хөршийн найрсаг хамтын ажиллагааны чиг шугамыг баримтлахын сацуу хамтын ажиллагаа, солилцооны замаар ойлголцол, итгэлцлийн түвшнээ тасралтгүй сайжруулах замаар хоёр орны харилцааг цуцалтгүй урагшлуулан хөгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

### **Хоёр. Хятад, Монголын сайн хөршийн харилцан итгэлцсэн түншийн харилцааг тогтоон хөгжүүлэх нь**

Хятад, Монголын найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхийн тулд өнгөрсөн жил БНХАУ-ын дарга Ху Жиньтао Монгол Улсад айлчлах үед хоёр тал хэлэлцэн тогтсон Хятад-Монголын сайн хөршийн харилцан итгэлцсэн түншийн харилцааг тогтоон хөгжүүлэх чухал нэгдмэл ойлголт болон энэ жил Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн Хятадад хийсэн айлчлалын үеэр гаргасан хамтарсан албан мэдэгдлийн үзэл санааг тууштай хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Үүний тулд дараах хэдэн саналыг дэвшүүлмээр байна.

1. Улс төрийн талаар харилцан итгэлцлийг тасралтгүй нэмэгдүүлж, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны эрчийг хүчтэй болгох нь.

Хоёр орны удирдагчдын дээд хэмжээний уулзалт яриа ба бүх салбарын солилцоог цаашид үргэлжлүүлэн гүнзгийрүүлэхийн хамт улс төрийн талаар харилцан итгэлцэхтэй нягт холбоотойгоор Хятад улс “Сайн хөрш, амгалан хөрш, баян хөрш”-ийн бодлогыг тууштай явуулан Монгол Улстай итгэлцэх явдлаа улам бүр нэмэгдүүлж, хамтдаа хөгжин цэцэглэх, Монгол Улстай өнөд мөнх сайн нөхөр, сайн хөрш, сайн түнш байхыг эрмэлзэж байна. Худалдаа, эдийн засгийн харилцаа нь Хятад-Монголын харилцааг улам гүнзгийрүүлэн хөгжүүлэх чухал үндэс суурь болж байна. Хятад, Монголын газар зүйн хувьд ойр дөт, хоёр талын худалдаа эдийн засгийн харилцан нөхөх болон хамтран ажиллах потенциал сайтай давуу талаа түшиглэн эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг улам ихээр нэмэгдүүлж, түүнийг шинэ түвшинд хүргэн хоёр тал харилцан ашигтай, хамтдаа амжилтанд хүрэх зорилгыг хэрэгжүүлмээр байна. Хэдийгээр Хятад, Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа түүхийн хамгийн оргил үедээ байгаа боловч алс хэтдээ энэ эрч хүчийг хадгалж байх үүднээс авч үзвэл хоёр орны хөрөнгө оруулалт, худалдаа Хятадын өргөн хэрэглээний барааг Монголын мал аж ахуйн бүтээгдэхүүн, эрдэс түүхий эдээр солих төдийд хязгаарлагдаж буй өнөөгийн төлөв байдлыг халан өөрчилж Ху Жиньтао даргын Монголд айлчлах үед хоёр тал хэлэлцэн тохирсон “уул уурхайн баялгийг ашиглаж дэд бүтцийг хөгжүүлэх нь цаашдын хөгжлийн гол салбар болно” гэсэн чухал үзэл санааг нэн даруй чармайн хэрэгжүүлэх нь урт хугацааны тогтвортой эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг хөгжүүлэх хамгийн үр ашигтай, зохистой арга зам юм.



2. Хятад, Монголын эдийн засаг, худалдааны харилцаанд буй бодит асуудлуудыг шийдвэрлэхийг чухалчлах нь.

Монгол Улс 1990-ээд оны дунд үеэс эхлэн гадаадын хөрөнгө оруулалтыг татах, уул уурхайн баялгаа нээн ашиглах, эдийн засгаа сэргээн хөгжүүлэх бодлого явуулж байгаа боловч өнөөг хүртэл Хятад, Монголын хооронд уул уурхайн дорвитой том төсөл хэрэгжүүлээгүй байна. Үүний гол шалтгаан гэвэл, 1-рт Хятадын үйлдвэр, аж ахуйн газрууд алс ирээдүйн стратегийг чадвар дутагдалтай, эрсдэлээс эмээх, урьдчилсан бэлтгэлд гаргах хөрөнгө зардалд гар татах, Монголын орчин нөхцөл дутмаг зэрэг хүчин зүйлийн улмаас бодит боломж нөхцлийг алдсан, 2-рт Монгол Улс шинэтгэлийн бодлого явуулснаас хойш дийлэнх уул уурхайн баялгийг эрж тандах, олборлох, эрхийг нэгэнт аж ахуйн нэгж, хувь хүмүүс мэдэлдээ авчихсан тул Хятадын талын аж ахуйн нэгжүүд оролцоход ихээхэн хүндрэлтэй. Үүнээс гадна үгүйсгэж болохгүй нэгэн зүйл бол Монголын нийгэм, улс төрийн зарим хүчнүүд Хятад улс Монголын эдийн засгийн олон салбарт түрэн орж үйл ажиллагаа явуулахад ихэд эмзэглэн ханддаг бөгөөд удаан хугацааны турш хятадууд Монголын эдийн засагт нэвтрэх болбоос Монгол Улс ирээдүйд хятад хүний гарт орно хэмээн санаа зовнидог. Хятадын тухайд гэвэл, Монголд дунд, урт хугацааны стратегийн хөрөнгө оруулалт, эрсдэлтэй хөрөнгө оруулалт хийх, засгийн газар улсын том дунд үйлдвэр, аж ахуйн газар, хүчтэй хувийн үйлдвэрүүдийг Монголд татан оруулах ажлыг зохион байгуулах замаар Монгол, Хятадын эдийн засаг худалдааны харилцаа урт хугацаанд үр ашигтай, нэр хүндтэй байх нөхцлийг хангах, улмаар Монголд бодит ашиг тусыг бий болгосноор тэдний санаа зовнилыг арилгах хэрэгтэй. Үүний зэрэгцээ хятадын талын нэр хүндийг унагаж буй яс чанар муутай хувийн бизнес болон хувь хүн мөн түүнчлэн хуурамч бараа бүтээгдэхүүн Монголд орох явдлыг шийдвэртэй таслан зогсоох хэрэгтэй. Монголын талын хувьд хөрөнгө оруулалтын орчин нөхцлөө цаашид сайжруулан төгөлдөржүүлэх арга хэмжээ авахын сацуу ашигт малтмалын лиценз бүхий аж ахуйн газар, хувь хүний лицензээ зарах, шилжүүлэх зохистой арга зам, нөхцөл бололцоог хуулийн дагуу бий болгох, ингэснээр Хятад, Монгол хоёр тал уул уурхайн салбарт илүү үр бүтээлтэй хамтран ажиллах болно.

3. Монгол, Хятадын харилцаанд Өвөр Монголын Өөртөө Засах Орны гүйцэтгэж буй өвөрмөц үүрэг холбогдлыг бүрэн дүүрэн ашиглах нь.

ӨМӨЗО нь Монгол Улстай 6 аймаг, 15 хошууны нийт 3193 км газраар хиллэдэг. Энэ нь Монгол, Хятадын хилийн нийт уртын 68,3%-

ийг эзэлдэг. Одоо хоёр орны хооронд 15 боомтоор нэвтэрч байгаагийн дотор Хятад, Монголын цорын ганц төмөр замын боомт болох Эрээн - Замын -Үүдийн боомтыг оруулаад 10 боомт нь Өвөр Монголд байна. Хэдийгээр хилийн хоёр талд хуваагдсан боловч Өвөр Монгол, Монгол Улс хоёр нь нэг хэл, соёл бүхий хил дамнасан нэг үндэстэн билээ. Иймд Өвөр Монголын газар зүйн байрлал, үндэстэн, соёлын давуу талаа ашиглаж, Хятад, Монголын харилцаанд гүүр, зангилаа газрын үүрэг гүйцэтгэх учиртай. Хойшид Өвөр Монгол, Монгол Улстай харилцахдаа, 1-рт, уул усаар холбогдсон газар зүйн давуу тал, хөрөнгө мөнгө, техник, хүн хүч харьцангуй баялаг давуу байдлаа ашиглан Монголын уул уурхайн салбарт шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх, ялангуяа Монголд нөөцөөр арвин, Хятадад бол өдрөөс өдөрт эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж буй газрын тос, төмрийн хүдэр олборлох зэрэг төслүүд дээр урт хугацаанд хамтран ажиллах, 2-рт, олон талын иргэд хоорондын солилцоо явуулж, хоёр ард түмний харилцан ойлголцол, худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, соёл боловсрол, аялал жуулчлал болон бусад олон хэлбэрийн солилцоо, хамтын ажиллагааг улам бүр өрнүүлснээр хоёр орны харилцааг хөгжүүлэх үйл хэрэгт түлхэн урагшлуулах үүргээ гүйцэтгэх, 3-рт, Өвөр Монгол, Монгол Улсын байгалийн байдал адил төстэй тул цөлжилтөөс сэргийлэх, хамгаалах, тал нутгийн экологийн орчинг хамгаалах талаар өргөн хүрээтэй хамтран ажиллах боломж байна. Энэ бол Хятад, Монгол хамтран ажиллахад хүргэж буй бас нэг шалтгаан, зах сэжүүр юм. Ойрын жилүүдэд хоёр орон шороон түйрэнгээс хүч хамтран сэргийлэх ажлыг нэгэнт эхлүүлээд байна. Энэхүү дэлхийн шинжтэй болж буй нийтийн гамшгийг бүрэн арилгахын тулд Хятад, Монгол хоёр нягт хамтран ажиллахаас гадна олон улсын хамтын нийгэмлэгээс өргөн дэмжлэг, хүчтэй зохицуулалт авах зайлшгүй шаардлагатай юм.

### **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

1. Монголын эдийн засаг, нийгэм 2003 онд. Монгол Улсын статистикийн газар, УБ, 2004 он
2. Д.Начин. Гадаадын шууд хөрөнгө оруулалт: дэлхий нийтийн хандлага ба Монгол Улс. “Олон улс судлал” сэтгүүд, 2004, №1
3. Өдрөөс өдөрт ойртож буй Монгол-Хятадын харилцаа. 2004.06.18 <http://www.people.com.cn>